



СОЁМБО

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

МЭДЭЭ

193 /193/

2021.12.03

ЦАГ ҮЕ, ҮЙЛ ЯВДАЛ

“ЗАСГИЙН ГАЗРЫН ЦОМ-2021” ТЭМЦЭЭН ЭХЭЛЛЭЭ

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Төрийн захиргааны төв байгууллагуудын дунд жил бүр уламжлал болон явагддаг спортын 4 төрөлт “Засгийн газрын цом-2021” тэмцээн өнөөдөр нээлтээ хийж байна. Энэ жилийн тэмцээнийг Байгал-Орчин аялал жуулчлалын яам зохион байгуулж байгаа бөгөөд өнөөдөр сагс болон гар бөмбөгийн төрлөөр тэмцээний салхийг хагалж байна. Гурван өдөр үргэлжлэх тус тэмцээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Батлан хамгаалах яам, Гадаад хэргийн яам, Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яам, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Барилга хот байгуулалтын яам, Боловсрол, Шинжлэх ухааны яам, Зам тээврийн хөгжлийн яам, Соёлын

яам, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Хүнс, хөдөө, аж ахуй хөнгөн үйлдвэрийн яам, Эрчим хүчний яам, Эрүүл мэндийн яам оролцож байна.

Ташрамд дурдахад өнөө жил эл тэмцээн нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Батлан хамгаалах яам, Гадаад харилцааны яам, Сангийн яам, Хууль зүй дотоод хэргийн яамны 110 жилийн ойн хүрээнд зохион байгуулагдаж буйгаараа онцлог юм.

Сонирхуулахад, уг тэмцээн анх 2005 онд Барилга, хот байгуулалтын яамны санаачилгаар Засгийн газар, яамдын хооронд сагсан бөмбөгийн төрлөөр зохион байгуулагдсанаас хойш “Засгийн газрын цом” нэртэйгээр, спортын 4 төрлөөр хүрээгээ тэлэн жил бүр уламжлал болон зохион байгуулагдаж байна.



Түүхэнд энэ өдөр

1934 он. Улсын VII их хурал “Улс орныг батлан хамгаалах тухай” Цэргийн яамны сайд бөгөөд БЦ-ийн жанжин Г.Дэмидийн илтгэлийг хэлэлцээд тогтоол гаргажээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-4	-22

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
39	24

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	2,852.0	2,854.0
EUR	3,220.0	3,235.0
CNY	446.3	447.0
RUB	38.00	39.40
JPY	24.88	25.47
KRW	2.38	2.46

ЗУРХАЙ

2021.12.03 БААСАН ГАРАГ
/БИЛГИЙН ТООЛЛЫН 29/

ӨВЛИЙН ТЭРГҮҮН
ШАРАГЧИН ГАХАЙ
САРЫН ДӨРВӨН НОГООН
МЭНГЭТЭЙХӨХӨГЧИН ТАХИА
ӨДӨР

Үс засуулбал:

Сүлд тэнэж одно

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

08.23-17.01

Барилдлага:

Шид

Шүтэн барилдлага:

Хурьцахуй

Суудал:

Шороо

Энэ өдөр үхэр, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба бар, туулай жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр буюн номын үйлд шамдах, бүтээл туурвил эхлэх, худалдаа арилжаа хийх, бизнес эхлэх, зэрэг дэв дэвших, лусыг тахи, хагалгаа хийлгэх, буг дарах, газрын ам бооход сайн. Мод суулгах, нарийн зөвлөгөөн хийх, сэтгэлд сэвтэй газар очих, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, бар, туулай, морь, хонь, тахиа болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

НИЙТ БҮРТГЭГДСЭН
372.964 +375

ЭДГЭРСЭН
536,920

НАС БАРСАН
1,938 +3

ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛЭГ

НИЙТ БАТЛАГДСАН
6544 +110

ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ
77

ЭДГЭРСЭН
6341

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол
Нийт: 264,473,438

Эдгэрсэн
Нийт: 238,491,434

Нас барсан
Нийт: 5,250,054

цаг үе, үйл явдал

“ЦЭРГИЙН АЛБАНЫ ХЭЛТЭС” ЖИЛИЙН АЖЛАА ТАЙЛАГНАВ



Цэргийн албаны хэлтсийн 2021 оны жилийн эцсийн тайлангийн хурал энэ сарын 2-ны өдөр боллоо. Хуралд ЗХЖШ-ын нэгдүгээр орлогч дарга хурандаа С.Ганбямба, ХЗЦ-ийн командлагч хошууч генерал Б.Амгаланбаатар, БХЯ-ны “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, дэг журам, сахилга хариуцлагыг бэхжүүлэх салбар зөвлөл”-ийн нарийн бичгийн дарга хурандаа Н.Пүрэвдорж, Зэвсэгт хүчний Хяналт шинжилгээ үнэлгээний газрын дарга хурандаа Ж.Өсөхбаяр, Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн захирагч, хурандаа Ж.Мөнхбаяр, төрлийн цэргийн командлагчын цэргийн алба хариуцсан офицерууд болон цэргийн хүрээ, хотхоны цэргийн цагдаагийн тасгийн дарга нар оролцлоо.

Цэргийн албаны хэлтэс нь ЗХЖШ-ын даргын 2020 оны Б/1800 дугаар тушаалаар байгуулагдаж Зэвсэгт хүчинд үйлдэгдэж байгаа гэмт хэрэг, осол, зөрчлийг илрүүлэн бүртгэн мэдээллийн сан бий болгож дүн шинжилгээ хийсний үндсэн дээр түүний шалтгаан нөхцөлийг тодорхойлж цаашид гэмт хэрэг, осол, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, Цэргийн цагдаагийн үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, дагах

мөрдөх баримт бичгийг боловсронгуй болгох зэрэг үндсэн үүргийг гүйцэтгэж байна.

Цэргийн албаны хэлтэс нь тайлангийн хугацаанд



үндсэн үүргийнхээ дагуу цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай ажилладаг салаа, салбарын офицер, ахлагч нарт сэтгэл зүйн карт, цэргийн алба хаагчдад хувийн хэрэг нээн түүнд тулгуурлан мэдээллийн санг бүрдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаандаа ашиглаж эхэлсэн юм.

Тус хэлтсийн хамт олон Зэвсэгт хүчинд сүүлийн 10 жилд гарсан гэмт хэрэг, сахилгын зөрчлийн дүн мэдээг нэгтгэн боловсруулж, түүнд дүн шинжилгээ хийн мэдээллийн санг бүрдүүлээд байгаа юм. Түүнчлэн энэхүү мэдээллийг ЗХЖШ-

ын зохион байгуулалтын бүтцийн нэгж, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллага тус бүрээр ангилан гаргаж 3, 5, 10 жилээр нь нарийвчлан судалж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлон ажиллаж байна.

2021 онд цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчидтай ажилладаг салаа, салбарын офицер, ахлагч нарт сэтгэл зүйн карт, цэргийн алба хаагчдад хувийн хэрэг нээн түүнд тулгуурлан мэдээллийн сан бүрдүүлж, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ашиглаж эхэлсэн юм. Мөн нэгтгэл, анги, байгууллагуудын салаа, рот, батальоны захирагч нарт

хөтлөгдөх цэргийн алба, сахилга зохион байгуулалт, сэтгэл зүй, соёл хүмүүжлийн ажилд ашиглах баримт бичгийн загварчлалыг к а л е н д а р ч и л с а н төлөвлөгөө, самбарын загвар, цэргийн алба болон цэргийн цагдаагийн холбогдолтой баримт бичгийг төрөлжүүлэн боловсруулж, өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн цэргийн алба хаагчдын эрх зүйн боловсролыг сайжруулах үүднээс Зэвсэгт хүчний үйл ажиллагаатай холбоотой хууль, эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх зорилгоор хууль болон сэтгэл зүйн кейс бүхий зурагт самбар бэлтгэж нэгтгэл, анги, байгууллагуудад ашиглахаар бэлтгэж буй юм.

Ийнхүү цэргийн албаны хэлтэс нь 2021 онд дэвшүүлсэн зорилго, зорилтоо ханган ажилласан ба ялангуяа цэргийн албаны төлөвлөлт зохион байгуулалтын чиглэлээр хэзээ ямар арга хэмжээг хэрхэн хэрэгжүүлэх, шат шатны орон тооны бус салбар зөвлөл, комиссуудын ажил үүргийн хуваарь, ажиллах журмыг нарийн тодорхойлон гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг чухалчилж байна.

Цэргийн албаны хэлтэс

30 КИЛОМЕТРИЙН МАРШ ҮЙЛДЛЭЭ

Зэвсэгт хүчний 326 дугаар анги

Ангийн 2021-2022 оны сургуулийн жилийн сургалтын төлөвлөгөөний дагуу байнгын бие бүрэлдэхүүн, цэргийн гэрээт болон хугацаат цэргийн алба хаагчдыг 3 бүлэгт хуваан тактик тусгай бэлтгэлийн цогцолбор 30 км-ийн явган маршийг хичээлийн дөрвөн цэгээр төлөвлөн зохион байгууллаа. Тодруулбал, хордсон газар орныг хэрхэн туулах, салаа давшилтад эзлэгдсэн гүүрийг яаж чөлөөлөх, цэргийн байр зүй, галын бэлтгэлийн хичээлийн цэгүүдийг хэрхэн төхөөрөмжлөх чиглэлээр сургалтууд амжилттай явагдсан юм. Мөн бие бүрэлдэхүүний их амралтын үед хээрийн



халуун хоол, цайгаар үйлчлэв.

Ахмад Л.ТҮМЭНДЭЛГЭР

БАРИЛГА-ИНЖЕНЕРИЙН ЦЭРГИЙН АНГИУД ХҮРЭЭГЭЭ ТЭЛНЭ



Монгол Улсын Засгийн газрын тогтоолоор Архангай, Говь-Алтай аймагт барилгын цэргийн анги байгуулагдахаар шийдвэрлэгдсэн билээ. Энэ хүрээнд Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын дарга хурандаа Х.Батсайханаар ахлуулсан ажлын хэсэг энэ сарын 1, 2-ны өдрүүдэд дээрх аймгуудад ажиллан аймгийн удирдлагуудтай уулзаж тухайн орон нутагт байгуулагдах барилга-инженерийн цэргийн ангийн үйл ажиллагааны онцлогийг танилцуулан санал солилцлоо.

Барилга-Инженерийн цэргийн удирдах газар

ИЖ БҮРЭН КАМЕРЖУУЛАЛТЫН СИСТЕМ



Баянгол дүүргийн ЗДТГ-ын Цэргийн штаб Өнгөрсөн сарын 25-ны өдөр зохион байгуулагдсан Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн хугацаат цэргийн

алба хаагчдын тангаргийн баярт ХЗЦК болон Баянгол дүүргийн албаны хүмүүс оролцсон юм. Энэ үеэр Баянгол дүүргийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх,



сахилга дэг журмыг бэхжүүлэх зөвлөлөөс тус ангид иж бүрэн камерын систем, эмнэлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж цар тахлаас урьдчилан сэргийлэх хамгаалалтын хувцас, хэрэглэл, ариутгалын бодис, амны хаалт, тангараг өргөсөн дайчдад дархлаа дэмжих амин дэмүүдээр гарын бэлэг бариллаа.

ГАР БӨМБӨГИЙН АВАРГУУД ТОДОРЛОО

Зэвсэгт хүчний 350 дугаар анги

Ангийн биеийн тамир спортын зөвлөл, гуравдугаар мотобуудлагын рот хамтран ангийн гар бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулав. Тэмцээнд нийт 9 баг тамирчин ур чадвар, авхаалж самбаа сорин өрсөлдсөнөөс ахмад Т.Эрдэнэсайхан захирагчтай 4МБР, Б.Галдан захирагчтай 3МБР, ахлах ахлагч У.Бат-



Эрдэнэ захирагчтай БХС-ын баг тамирчид эхний байруудад шалгарлаа.

Ахмад Б.ДЭРДЭНЭНИНЖ

"КАРАОКЕ" ДУУНЫ ТЭМЦЭЭНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАВ



Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэл

Тус нэгтгэлийн 2021-2022 оны сургуулийн жилд зохион байгуулж байгаа тасаг, алба сурталчлах 7 хоногийн аяны хүрээнд захиргааны удирдлагын тасгаас "Кароке" дууны тэмцээнийг зохион байгууллаа. Багийн мэндчилгээ, гоцлол дуу, харилцаа дуу гэсэн 3 үе шаттайгаар зохион байгуулсан эл тэмцээнд Мотобуудлагын батальоны "Таван эшиг" баг тэргүүлж, "Холбоочин дайчин" баг удааллаа. Харин шилдэг гоцлол дуучнаар цэргийн гал тогооны бэлтгэгч Б.Энхжаргал шалгарав.

Хошууч Д.ДОЛГОРЖАВ



Дарга, ерөнхий редактор, хурандаа САНЖМЯТАВЫН ТӨМӨРХҮЯГ



ЦАХИМ ХАЯГ



Батлан хамгаалах яам



Зэвсэгт хүчний Жанжин штаб



ЦАХИМ ХУУДАС



"Соёмбо" сонин



"Дуулга" студи

* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний мэдээ мэдээллийг шуурхай нийтэлнэ.
* Батлан хамгаалах, Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага хамт олны түүхт ой, тэмдэглэлт өдрүүдэд зориулсан тусгай дугаарыг бэлтгэнэ.
* Тус сонин мэдээллийг эх сурвалжийг дурьдан ашиглаж болно.

Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон Индекс: 10018

Цахим шуудан: Soyombo@mod.gov.mn Утас: 70001029, 3412 (дотуур)